

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2019.04.04

Дугаар: №09

Баруун-Урт хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолыг чиглэл болгон баримталж нэг талаас Нутгийн захиргааны байгууллага, түүнийг төлөөлж аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар, тухайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай хамаарах сум түүнийг төлөөлж, Сүхбаатар сумын Засаг дарга Г.Хүрэлсүх, Асгат сумын Засаг дарга У.Мөнхбаяр нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж "Дорнын чулуулаг" ХХК түүнийг төлөөлж, гүйцэтгэх захирал Ц.Адъяатогтох (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр энэхүү гэрээг байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 4-р баг, Асгат сумын 1-р багийн нутаг дэвсгэрт "Ашигт малтмалын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд төр хувийн хэвшлийн түншлэлээр сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн захиргааны байгууллагатай байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү гэрээтэй холбоотой харилцааг "Монгол улсын Үндсэн хууль", "Ашигт малтмалын тухай хууль", "Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль", "Хөрөнгө оруулалтын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2. Талуудын харилцаа

2.1 Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум, Асгат сум болон тусгай зөвшөөрөл эзэмшигч "Дорнын чулуулаг" ХХК хоорондын хамтын ажиллагааг энэхүү гэрээгээр зохицуулна.

2.2 Талууд нь энэхүү гэрээг байгуулахдаа уурхайн талбай харьяалагдах сум, аймгийн нутгийн захиргааны байгууллага тэдгээрээр дамжуулан орон нутгийн ард иргэдийн саналыг гэрээний төсөлд тусган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн баталсан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулна.

3. Аймаг, сумын Нутгийн захиргааны байгууллагын эрх үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд аймаг, сумын Засаг дарга нар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулахад дэмжиж ажиллана.

3.1.2 Үйлдвэр, уурхай, суурин түүний цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах, зам гүүр, барилга байгууламжийн газар олголт, бусад шаардлагатай зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

3.1.3 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдийг тогтмол мэдээллээр хангана.

3.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

3.1.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан санал хүсэлтийг төрийн холбогдох байгууллагуудтай хамтран хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг албан бичгээр хүргүүлнэ.

3.1.6 Энэхүү гэрээнд заасан үүргээс гадуур өөр бусад мөнгөн тусламж дэмжлэг, хандивыг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахгүй.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

4.1 Ашиглалтын үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саатуулах, таслан зогсоосон аливаа үйл ажиллагаа гарсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Нутгийн захиргааны байгууллага, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

4.2 Нутгийн захиргааны байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй.

4.3 Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээлэл авах эрхтэй.

4.4 Гэрээт талбай болон уурхайн эдэлбэрээс ашигт малтмал хайх, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах, хөдөлмөр эрхлэлт болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, стандарт дүрэм, журмын дагуу явуулна.

4.5 Компанийн салбарыг 2019 онд орон нутагт нээж аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэст тус мэдэгдэж бүртгүүлнэ. /Орон нутаг хариуцсан Төлөөлөгч томилох/

4.6 Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрыг компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр тогтмол хангаж ажиллана.

4.7 Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг, сумын иргэдэд мэдээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тэдний санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэн ажиллана.

4.8 Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах салбарын нэгдсэн арга хэмжээнд идэвхи санаачлагатай оролцоно.

4.9 Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу ажиллах хүчний талаар тавигдах шаардлагыг хангаж, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас холбогдох зөвшөөрөл, дэмжсэн албан бичгийг авна.

4.10 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлнэ.

4.11 Аймаг, сумын нутгийн захиргааны цахим хуудсанд компанийн мэдээллийг ил тод байршуулж, шинэчлэлт баяжилт хийх мэдээллээр хангах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар, аймаг сумдын ОУИТБС-ын дэд зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

4.12 Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран уул уурхайн салбарын мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, иргэдийг ил тод мэдээллээр хангах ажилд 1.000.000 /Нэг сая/ төгрөгийн хөрөнгийн дэмжлэг үзүүлнэ.

4.13 Аж ахуй нэгж нь гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр дотооддоо сургалтын төлөвлөгөө боловсруулж, цагдаагийн газартай хамтран сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

5. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

5.1 Үндсэн үйл ажиллагааг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай явуулах, нөхөн сэргээлтийг хууль тогтоомжийн дагуу хийнэ.

5.2 Ашиглалтын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, сөрөг нөлөөлөл бий болж, байгаль орчны бохирдол үүссэн тохиолдолд нөхөн сэргээх ажлыг хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгч, 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэнэ.

5.3 Уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн буюу өртөж болзошгүй ард, иргэдийн хохирлыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр нөхөн олговор олгоно.

5.4 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг стандартын дагуу чанартай гүйцэтгэж, журамд заасан хугацаанд менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж ажиллана.

6. Бүтээгдэхүүн тээвэрлэлт, авто замын засвар, арчлалтын чиглэлээр:

6.1 Бүтээгдэхүүн тээвэрлэлтийг Төрийн захиргааны төв байгууллага болон Нутгийн захиргааны байгууллагаас баталсан чиглэлийн дагуу явуулж, авто замын засвар, арчлалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

6.2 Батлагдсан чиглэлээс гадуур тээвэрлэлт явуулж олон салаа зам үүсгэж хөрсний доройтол, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.

6.3 Авто замын тухай хууль, холбогдох журам, уурхайн ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсаны дагуу бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замыг хатуу хучилттай болгох талаар холбогдох арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах.

7. Ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүч сонгох, хөдөлмөр эрхлэлт, ажиллагсадын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр:

7.1 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж тэднийг шаардлагатай сургалтад хамруулан ажлын байраар хангах талаар Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, орон нутгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллаж, уурхайн нийт ажиллагсдын 80-иас доошгүй хувийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад бүртгэлтэй тухайн сумын иргэдээс тэргүүн ээлжинд сонгох.

7.2 Шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлан сонгон шалгаруулах.

7.3 Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулна.

7.4 Өөр орон нутгаас зайлшгүй шаардлагаар ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлнэ.

7.5 Бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэх болон ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгохдоо ил тод, нээлттэй зохион байгуулан орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт давуу эрх олгон жилийн нийт худалдан авалтын 50-иас доошгүй хувийг орон нутгийн татварын хэлтэст бүртгэлтэй аж ахуйн нэгж болон тухайн сумын иргэдээр гүйцэтгүүлэх, гэрээ байгуулж ажиллах.

7.6 Ажилтан ажиллагсдын ажиллах, амьдрах орчин нөхцлийг Монгол улсын холбогдох хууль, тогтоомж дүрэм, журам, стандартад нийцүүлнэ.

7.7 Компанид ажиллаж буй Монгол ажилтан, ажиллагсадын цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газраас баталсан Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарын дундаж цалингаас доошгүй байлгана.

7.8 Компаний хүний нөөцтэй холбоотой баримт бичгийг төрийн архивт шилжүүлэх.

8. Орон нутгийн хөгжил, төсөл хөтөлбөрийг дэмжих чиглэлээр:

8.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж "Дорнын чулуулаг" ХХК нь аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, орон нутгийн бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинээр ажлын байр нэмэгдүүлэх үйл ажиллагаанд зориулан 20 000 000 /Хорин сая/ төгрөгийг Сүхбаатар аймаг Төрийн сан банк 100120000955 /бусад орлого/, Сүхбаатар суманд 12 000 000 /Арван хоёр сая/ төгрөгийн дэмжлэгийг Төрийн сан банк 100120700995 дансанд, Асгат суманд 18 000 000 /Арван найман сая/ төгрөгийн дэмжлэгийг Төрийн сан банк 100120100955 дансанд тус тус орон нутгийн төсөвт шилжүүлнэ.

8.2 Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг, орон нутгийн иргэдэд уул уурхайн үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, чадавхижуулах, туршлага судлах зэрэг ажил зохион байгуулахад 2 000 000 /Хоёр сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.

8.3 Нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах "Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа 2019" уул уурхайн орон нутгийн зөвлөгөөнд дэмжлэг үзүүлж хамтран зохион байгуулна.

8.4 Аж ахуй нэгж 8.1-д заасан мөнгөн дэмжлэг аймагт 20 000 000 /Хорин сая/ төгрөг, Асгат суманд 18 000 000 /Арван найман сая/ төгрөгийг тухайн оны 6 дугаар сарын 01-ны дотор, Сүхбаатар суманд 12 000 000 /Арван хоёр сая/ төгрөгийг 9 дүгээр сарын 01-ний дотор тус бүр төсвийн орлогын дансанд шилжүүлсэн байна.

8.5 Орон нутгийн иргэдэд мэдээлэл олгох, туршлага судлах сургалт, сурталчилгааны ажилд зориулах төлбөр 2 000 000 /Хоёр сая/ төгрөгийг "Бичигт их өргөө" ОНӨААТҮГ, регистрийн дугаар 3678512, Хаан банкны 5630500567 дансанд 2019 оны 06-р сарын 01-ний дотор шилжүүлнэ.

8.6 Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран уул уурхайн салбарын мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, иргэдийг ил тод мэдээллээр хангах ажилд зарцуулах 1.000.000 / Нэг сая/ төгрөгийн хөрөнгийн дэмжлэгийг 3681173 регистр дугаартай Сүхбаатарын Өнгө ХМБ-ын Хаан банкны 5648117564 дансанд 2019 оны 06-р сарын 01-ны дотор шилжүүлнэ.

8.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг гэрээнээс гадуурх улс төрийн нам, төрийн бус байгууллагууд, төрийн албан хаагчдаас ирсэн хандив тусламжийн хүсэлтийг хүлээн авахгүй ба энэ талаарх мэдээллийг талуудад тухай бүр мэдээлнэ.

8.8 Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр, гүйцэтгэх хугацаа, төсөвт өртөг, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг талууд хавсралтаар баталгаажуулж болно. Энэхүү төлөвлөгөө нь гэрээний салшгүй хэсэг байна.

9. Хамтын ажиллагааны хороо

9.1 Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г тухайн орон нутгийн иргэдийн төлөөлөл, Нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг оролцуулан байгуулж ажиллуулна.

9.2 Аймгийн Засаг дарга хорооны ажиллах журмыг батлах бөгөөд бүрэлдэхүүнийг сумын Засаг дарга нэр дэвшүүлж аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

9.3 Хороо нь талуудын оролцоог тэгш хангасан 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд иргэдийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ.

10. Гэрээ тайлагнах, дүгнэх

10.1 Хамтын ажиллагааны хороо нь гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг аймаг, сумын Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

10.2 Гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар тухайн шатны Засаг дарга иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

10.3 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

11. Гэрээний хариуцлага, маргаан шийдвэрлэх

11.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу зохих хариуцлага хүлээх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

11.2 Талууд нь энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой үл ойлголцол, маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

12. Гэрээний хугацаа, бусад

12.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 01 хүртэл хугацаанд мөрдөгдөнө.

12.2 Хэрэв холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт орсон нь энэ гэрээг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхөөр бол гэрээний нэг тал нь нөгөө талдаа бичгээр мэдэгдэл өгч, тухайн асуудлыг хэрхэн зохицуулах талаар харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

12.3 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

12.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

12.5 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ

АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА Ж.ОРДЭНЭБААТАР

СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ

ДАРГА Г.ХҮРЭЛСҮХ

АСГАТ СУМЫН ЗАСАГ

ДАРГА У.МӨНХБАЯР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ

"ДОРНЫН ЧУЛУУЛАГ" ХХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛ Ц.АДЪЯАТОГТОХ

ГЭРЭЭНД ЗААСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ: СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ж.ЭРДЭНЗБААТАР

д/д	Хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, дэмжлэг	хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Төсөвт өртөг
1	Орон нутгийн залуучуудыг их дээд сургуульд сургах, төгсөөд мэргэжлээрээ орон нутагаа ажиллахыг дэмжих зорилготой оюутны тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж, Сүхбаатар сум, Асгат сумаас тус бүр 5 оюутныг хамруулан сургалтын төлбөрийг шилжүүлнэ.	2019 онд	Сүхбаатар, Асгат сумын ЗДТГ	"Дорнын чулуулаг" ХХК
2	Сүхбаатар сум, Асгат сумын аж ахуй нэгж байгууллагуудад хөнгөлөлттэй үнээр нүүрс худалдан борлуулна.	2019 онд	Сүхбаатар, Асгат сумын ЗДТГ	"Дорнын чулуулаг" ХХК
3	Асгат сумын 1-р баг, Сүхбаатар сумын 4-р багийн өрх бүрийг 2 тонн нүүрсээр хангана.	2019 онд	Сүхбаатар, Асгат сумын ЗДТГ	"Дорнын чулуулаг" ХХК

ЗӨВШӨӨРСӨН:

СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Г.ХҮРЭЛСҮХ

АСГАТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА У.МӨНХБАЯР

"ДОРНЫН ЧУЛУУЛАГ" ХХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.АДЪЯАТОГТОХ